



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 оны 1 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар XIX/95

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Улсын Их Хурлын 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл хийх болсныг Танд үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Г.ЗАНДАНШАТАР

000104

## **“ЭЛЭГ БҮТЭН-МОНГОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Иргэдийн эрүүл мэнд, амь насанд аюул, эрсдэл учруулаад байгаа элэгний вирусын халдвартыг эрт илрүүлж, оношлох, эмчилгээнд хамруулах, эрүүл мэндийн байдлыг хянах зорилгоор “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоолоор батлан, хэрэгжүүлж байна.

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрт Монгол Улсын хүн амын дунд хепатитийн вирусын халдвартын тархалтыг хязгаарлан, хепатитийн С вирусын халдвартын шинэ тохиолдлыг 2020 он гэхэд таслан зогсоож, хепатитийн вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас барагчыг эрс бууруулах зорилго, 4 зорилтыг дэвшүүлэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн эхний шатанд хепатитийн В, С вирусын халдвартай байх өндөр эрсдэлтэй бүлэг буюу 40-65 насны иргэдийг шинжилгээ, оношилгоо, эмчилгээнд хамруулахаар зорьж ажилласан.

**Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах 5 чиглэлээр багцлан танилцуулж байна:  
Нэг. Зохион байгуулалтын чиглэлээр**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ын 2.2.2-ын 1 дүгээр зорилтод “Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.3.1-д “Элэг бүтэн-Монгол хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлэх талаар тусгасны дагуу төр, хувийн хэвшил, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоог хангасан ажлын хэсэг байгуулан хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоолоор баталсан.

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг улсын хэмжээнд 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулсан. Мөн хөтөлбөрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийг сурталчлах өдөрлөгийг Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдтэй хамтран 15 аймаг, нийслэлд зохион байгууллаа.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай цахим хурал хийж, тулгамдсан асуудлыг хамтран шуурхай шийдвэрлэж ажилласан.

Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам”-ыг боловсруулж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор хепатитийн В, С вирусын эрт илрүүлэг шинжилгээний өртгийг 2800 төгрөг

байхаар, 2017 оны 9 дүгээр тогтоолоор С вирусын идэвхжлийг бүрэн автомат аппаратаар хэмжих зардлыг 120000 төгрөг, хагас автомат аппаратаар хэмжих зардлыг 80000 төгрөг байхаар үнийн дээд хязгаарыг тогтоож, төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн.

Энэхүү санхүүжилтээр эрүүл мэндийн даатгалд хамрагдсан 40-65 насны иргэдэд хепатитийн С, В вирусын илрүүлэх шинжилгээг өрх, сумын эрүүл мэндийн төвөөр, хепатитийн С вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээг сонгон шалгаруулалтад тэнцсэн төр, хувийн хэвшлийн 22 лабораториар хийлгүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/94, А/193 дугаар тушаалаар “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 40-65 насны даатгуулагчийг хепатитийн В, С вирусын эрт илрүүлэг, шинжилгээнд хамруулах, санхүүжүүлэх эрүүл мэндийн байгууллага, нийгмийн даатгалын байгууллага, даатгуулагчийн эрх, үүргийг тогтоосон.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтын дагуу худалдан авах үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрууд зохион байгуулж, эрт илрүүлгийн хурдавчилсан оношлуурыг нийлүүлсэн.

Хепатитийн В, С вирусын эрт илрүүлэг, шинжилгээнд иргэдийг хамруулах үйл ажиллагааны зохион байгуулалт, уялдааг хангах зорилгоор “Хамтран ажиллах гэрээний загвар”-ыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/223 дугаар тушаалаар баталж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүд гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн мэдээний санг “elegbuten.mohs.mn” вэб сайтад суурилсан цахим программд үүсгэн, эрт илрүүлэг, С вирусын ачаалал тоолох шинжилгээ, вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан иргэдийг бүртгэн, 7 хоног бүрийн Даваа гаригт мэдээллийг тогтмол гаргаж, шийдвэр гаргагчид болон холбогдох албан тушаалтнуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн яам нь Ази, Номхон далайн орнуудын Элэг судлалын холбоо, Монголын элэгний эмгэг судлалын холбоотой эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг өөрийн оронд болон гадаадын өндөр хөгжилтэй орнуудад сургах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, мэдээ мэдээллэл солилцох чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, томоохон хувийн хэвшлийн эмнэлгүүд нийслэлийн хэмжээний зорилтолт бүлгийн үйлчлүүлэгч олонтой аж ахуй нэгж, байгууллага дээр очиж ажилласан.

“Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн дунд болзолт уралдааныг зарлан ажиллаж байна.

### **Хоёр. Санхүүжилт, хөрөнгө оруулалтын чиглэлээр**

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор хепатитийн В, С вирусын эрт илрүүлэх шинжилгээний өргтийг 2800 төгрөг, 2017 оны 9 дүгээр тогтоолоор С вирусын идэвхжлийг бүрэн автомат аппаратаар тодорхойлох зардал 120000 төгрөг, хагас автомат аппаратаар тодорхойлох зардал 80000 төгрөг байхаар үнийн дээд хязгаарыг тогтоож, зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн талаар дээр дурьдсан.

Аймаг, нийслэлийн хэмжээнд элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулах иргэдийн тоо, шаардагдах төсөв болох нийт 1.095,2 (нэг тэрбум ерэн таван сая хоёр зуун мянга) мянган төгрөгийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн A/200, мөн оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн A/373 дугаар тушаалаар Эрүүл мэндийн даатгалын сангаас олгохоор хуваарилан, гүйцэтгэлээр санхүүжүүлж байна.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгааг авч, олон улсын түншлэгч байгууллагад хүсэлт тавьснаар, одоогоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нэг бүр нь 1,179,200 (нэг сая нэг зуун далан есөн мянга хоёр зуу) төгрөгийн үнэ бүхий 97 ширхэг центрафугийг нийлүүлээд байна. Мөн Халдварт ёвчин судлалын үндэсний төвийн нөөцөнд байсан сорьц тээвэрлэх 54 савыг аймгуудад хуваарилсан.

Элэгний С вирусын эсрэг 5 нэрийн эмийг хайрцаг тутамд нь 210000 төгрөг, нэг курс эмчилгээнд 630,000-1,260,000 төгрөгөөр хямдруулан олгож, зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна.

### **Гурав. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр**

Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2016 оны суурин хүн амын тооноос хепатитийн вирусын эрт илрүүлгийн хамралтын хувийг гаргаж байгаа бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар хепатитийн В, С вирусын эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд нийт **346302** даатгуулагч хамрагдаад байгаа нь 40-65 насны нийт иргэдийн 46.2 хувийг эзэлж байна. Аймгууд дахь хепатитийн В, С вирусын эрт илрүүлэх шинжилгээнд хамрагдсан түвшин дунджаар 58,3 хувьтай байна.

Шинжилгээнд хамрагдсан **30537** иргэнд (8,9 хувь) хепатитийн В вирус эерэг гарсан бол **55181 иргэнд С вирус** эерэг гарч, С вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээнд **35216** даатгуулагч/иргэн/ хамрагдаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 3.3 тэрбум төгрөг санхүүжүүлээд байна. Эдгээр С вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдсан иргэдийн **17500** иргэн (49,7хувь) С вирусын идэвхжилтэй гарсан байна. Иймд эдгээр иргэд цаашид С вирусын халдварын эсрэг эмчилгээ хийлгэх шаардлагатай болоод байна.

2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар С вирусын халдвартын эсрэг эмчилгээнд нийт 17395 даатгуулагч хамрагдаад байгаа бөгөөд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас эдгээр иргэдийн эмчилгээнд нийт 6,9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт олгоод байна.

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор зохион байгуулсан өдөрлөгийн явцад иргэдийг хепатитийн В, С вирусын халдвараас гадна зүрх судас, хавдар, сурьеэ, хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн зэрэг төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэгийг 20 гаруй мянган хүнд хийж, шинжилгээ, оношилгоонд хамруулснаас 73 хүн хавдартай, 9 хүн халдвар бүхий сурьеэтэй, сурьеэгийн сэжигтэй 29 иргэн илэрснийг эмчилгээнд хамрууллаа.

Мөн хепатитийн В вирус илрээгүй иргэдийг сайн дурын дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж, нийт 73,869 гаруй иргэдийг хамруулаад байна.

### **Дөрөв. Эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах чиглэлээр**

Ази, Номхон далайн орнуудын Элэг судлалын холбооны “Элэгний С вирус ба хавсарсан халдвар” олон улсын хурлыг Монголын элэгний эмгэг судлалын холбоотой хамтран зохион байгуулсан. Уг хуралд 21 орны 35 эрдэмтэн судлаачид, манай улсын 200 гаруй эрдэмтэн, судлаач, эмч, мэргэжилтнүүд оролцсон.

Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа дотор, халдвартын чиглэлээр мэргэшсэн 261 эмчийг сургалтад хамруулж, С вирусын эсрэг эмчилгээ шаардлагатай иргэдэд эрүүл мэндийн даатгалын жороор олгох эмийг бичих зөвшөөрөл олгон, иргэдийг хяналтанд авч эмчилгээний үр дүнг тооцон ажиллаж байна.

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн мэдээллийн сан бүхий “elegbuten.mohs.mn” вэб сайтад суурилуулсан цахим программыг хөтлөх сургалтад аймаг, нийслэлийн мэдээлэл технологийн мэргэжилтнүүд, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг оруулах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын статистикч эмч нарыг цахим болон танхимиын сургалтад үе шаттайгаар хамруулсан.

### **Тав. Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр**

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нээлтийн үйл ажиллагааг 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж, хөтөлбөрийн талаар сурталчилсан богино хэмжээний видео бэлтгэн Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз, Монгол HD, TV5 телевиз зэрэг бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээллээ.

Үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд эрүүл мэндийн болон эрүүл мэнд нийгмийн даатгалын байгууллагуудын ажилтнуудыг оролцуулан Сүхбаатарын талбайд нээлттэй өдөрлөг хэлбэрээр зохион байгуулж, иргэдэд “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн талаар тайлбарлан, зөвлөгөө өгсөн. Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд 2500 гаруй иргэд оролцсон бөгөөд 4000 ширхэг гарын авлага, 4000 ширхэг 2 төрлийн, 4 нүүр бүхий тараах материал, бусад төрлийн сурталчилгааны материал 5000 гаруйг түгээллээ. Мөн “Элэг бүтэн-

Монгол” үндэсний хөтөлбөрийг онлайнаар сургалчилж, 9000 гаруй хандалт аваад байна.

Элэгний үрэвсэлтэй тэмцэх дэлхийн өдөр болох 7 дугаар сарын 28-ны өдрийг “Хепатитийг устгая” уриатай “Вируст хепатитийн эсрэг хамтдаа” өдөрлөгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагатай хамтран зохион байгуулж, иргэдэд төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг хийж, элэгний В, С вирусын түргэвчилсэн оношилгоо, ясны сийрэгжилт, биеийн ерөнхий үзүүлэлт, зөв хооллолтын талаар зөвлөгөө өгч, мэдээлэл сургалчилгааны 2000 ширхэг материал олон нийтэд түгээсэн. Уг арга хэмжээг 13 телевиз, 2 сонин, 2 цахим хуудсаар нийтэд сургалчиллаа.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвааес 3 төрлийн, 16 инфографик боловсруулан, нийт 959000 хүнд мэдээлэл хүргэж, 1352 хүн цааш түгээсэн байна. Элгэнд тустай 11 хүнс, “Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийн нээлт, явцын мэдээллийг газрын зургаар, хөтөлбөрт хэрхэн хамрагдах талаарх мэдээллийг [www.ncph.gov.mn](http://www.ncph.gov.mn) сайтаар дамжуулан тогтмол хүргэж байна. “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн нээлтийн мэдээлэл болон шторкийг нүүр хуудсаар төлбөртэй сургалчилсан.

### **Зургаа. Эрдэм шинжилгээ судалгааны ажлын чиглэлээр**

“Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын эрдэмтэн, судлаачид 2016-2017 онд хепатитийн вирусын халдварт, оношилгоо, эмчилгээний талаар нийт 33 өгүүлэл, илтгэлийг гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн байна.

Мөн Монголын элэгний эмгэг судлалын холбоо /МЭЭСХ/ “Монгол Улсад элэгний С вирусын халдварт ба хавсарсан халдварт” сэдэвт Ази, Номхон далайн орнуудын 6 дугаар их хурлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр 2017 оны 6 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг их хуралд 300 гаруй эрдэмтэн, судлаачид оролцож, өөрсдийн судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүллээ.

Энэ 2017 оны 11 дүгээр сард Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн хепатитын холбоо, Бразил Улсын Засгийн газар хамтран Бразил Улсын Сан Пауло хотод зохион байгуулсан “Дэлхийн хепатитийн дээд хэмжээний чуулган”-д манай улсаас Эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулсан баг оролцож, туршлага солилцсон бөгөөд Монгол Улс нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн “Хепатитгүй Ирээдүйн төлөө Манлайллагч” дэлхийн хөдөлгөөний манлайллагч улсаар зарлагдсан.

Чуулганы үеэр Монгол Улсын Эрүүл мэндийн дэд сайд Бразил, Бангладеш, Египет, Гамби зэрэг улсын Засгийн газрын төлөөлөгчидтэй хамтран Засгийн газрууд 2030 он гэхэд хепатитийн вирусын халдварт тархалтыг таслан зогсох ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй үйл ажиллагааг дэлгэрүүлэх, сургамжаа хуваалцахад татан орцуулахад чиглэсэн дэлхийн хэмжээний арга хэмжээ болох “Хепатитгүй Ирээдүйн төлөө Манлайллагч” хөтөлбөрийн хэрэгжилтийг эхлүүлсэн.

“Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, судалгаа шинжилгээний ажлыг

өргөжүүлэх чиглэлээр “Вируст хепатитийн илрүүлэг, тандалт, оношилгоо, эмчилгээг сайжруулах” төсөл боловсруулан, Азийн хөгжлийн банкинд хандаж дэмжүүлээд байна.

Манай эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа зарим төрийн бус байгууллага, олон улсын болон хамтын ажиллагаатай байгууллагатай хамтран дараах судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэж байна:

- Элэгний В, С вирусын молекул биологи, иммунологийн шинжилгээ хийж байгаа лабораторийн чанарын менежментийн өнөөгийн байдлыг үнэлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, цаашид үе шаттайгаар лабораторийн шинжилгээний чанарыг сайжруулах ажлыг 2017 оны 7 дугаар сараас Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр эхлүүлсэн. Энэ ажлын үр дүнд элэгний В, С вирусын молекул биологи, иммунологийн шинжилгээ хийж байгаа лабораториудын шинжилгээний чанарыг гадаад үнэлгээнд хамруулан лаборатори хоорондын шинжилгээний зөрүүг арилгаад байна.

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төвтэй хамтран хепатитийн вирусын халдвартын тархалтын судалгааг хийхээр санал солилцож байна.

- АНУ-ын Жонс Хопкинсын Нийгмийн Эрүүл мэндийн сургуультай хамтран Улаанбаатар хотын жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах вируст хепатитын тархалт, эхээс урагт дамжилт, сэргийлэх арга замын талаарх эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байна.

- АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгийн Цус сэлбэлтийн хүрээлэнтэй хамтран В эсийн Ходжкины бус лимфома үүсэхэд хепатитын В, С вирусын хамаарал, вирусын эсрэг эмчилгээний талаар, АНУ-ын Техасын Анаагаах Ухааны Их Сургуультай хамтран Монгол хүн амын дундах IL28b генийн полиморфизмыг хепатитийн D вирусын аяндаа арилах байдалтай холбогдуулан судлах талаар эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байна.

- АНУ-ын Сан-Франциско дахь Анаагаах Ухааны Их сургуультай хамтран “Монгол Улсын 24 хүртэлх насны хүн амын дундах вируст хепатитийн тархалтын өнөөгийн байдал” сэдэвт 4 судалгааны ажлын арга аргачлалыг батлуулан, Анаагаахын ёс зүйн хорооноос зөвшөөрлийг авч судалгааг АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгийн санхүүжилтээр эхлүүлээд байна.

Мөн Олон улсын элэг судлалын холбоо, нийгэмлэгийн 2 удаагийн хуралд төр хувийн хэвшлийн эмч, мэргэжилтэн, эрдэмтдийн бүрэлдэхүүнтэй баг илтгэл тавин оролцлоо.

## ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

- Хепатитийн В, С вирусын эрт илрүүлгийн хамрагдалтын байдал хангалтгүй байгаа нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэд олон байгаатай холбоотой юм. Иймд иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг орон нутагт идэвхжүүлэх;

- Вирусын халдвартай боловч эмчилгээнд бүрэн хамрагдахгүй байгаа нь иргэдийн эрүүл мэндийн боловсролтой холбоотой тул ухуулга, сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх;
- Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР